БАТЛАВ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДАРГА Н.УУГАНБАЯР

2025 оны 01 дүгээр сарын 23 өдөр

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 23 Улаанбаатар хот

| № | Үйл ажиллагаар хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцах нэгж, албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр** | | | | |
| 1 | Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэх | Жилдээ | Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчилсан байх | Захиргаа, удирдлагын газрын олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн |
| 2 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>➢ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2; | Тухай бүр | Монгол Улсын хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын төсөлд санал боловсруулах, зохих шатанд хүргүүлэх | Захиргаа, удирдлагын газрын хуулийн мэргэжилтэн |
| 3 | | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулах | Захиргаа, удирдлагын газрын олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн,<br>Мэдээллийн технологийн хэлтэс |
| 4 | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;<br>➢ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2; | | АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, инстаграм youtube суваг)-нд байршуулах | Захиргаа, удирдлагын газрын олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн |
| 5 | | | Байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар цахим хуудсанд нээлттэй байршуулах | |

D:\DATAwin05\ГИХГ\ЕВАТ\Tel-gee\2025 ATG tel-gee.docx

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах, шалгах<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;<br>➢ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2;<br>➢ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;<br>➢ Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг; | Жилдээ | Өргөдөл /санал, хүсэлт, мэдэгдэл/, гомдол, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх /утас, санал хүсэлтийн хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр/ | Захиргаа, удирдлагын газрын өргөдөл гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| 7 | | Тухай бүр | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан болон өргөдөл гомдол хариуцсан албан хаагч нарын нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах | |
| 8 | | Сар бүр | Иргэдийн өргөдөл, санал, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх | |
| 9 | | 12 сарын 30, дараа оны 1 дүгээр сард | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газрын авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” цахим системд тайлагнах | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан |
| 10 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>➢ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2; | Жилдээ | Гадаадын иргэн, харьяатын газраас олгодог лавлагаа, тодорхойлолт, зөвшөөрлийн үйлчилгээг бүрэн цахимд шилжүүлэх, цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах, тухай бүр шинэчлэх | Виз, зөвшөөрлийн газрын дарга, ахлах мэргэжилтэн, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн |
| 11 | | Тухай бүр | Байгууллагаас олгож буй зөвшөөрлийг шийдвэрлэх журам, зааврын тухай мэдээллийг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийтэд нээлттэй байршуулах | Захиргаа, удирдлагын газрын олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн |
| **Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр** | | | | |
| 12 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>➢ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3; | Тухай бүр | Сул орон тооны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудас, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлах | Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөл |
| 13 | | | Тухайн орон нутаг, хилийн боомтод ажиллаж байгаа төрийн тусгай албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг (ХАСУМ) болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг бүртгэх, хяналт тавих | Хилийн боомт, орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтэн, салбар эрх бүхий албан тушаалтан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14 | | | Тухайн жилд шинээр, шилжин, дэвшин, сэлгэн томилогдох албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан |
| 15 | | Улирал тутам | Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг албан хаагч, иргэдэд нээлттэй хүргэх | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн |
| **Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод болгох чиглэлээр** | | | | |
| 16 | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3; | 1 дүгээр улиралд | Тухайн жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсанд байршуулсан байх | Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагч |
| | | Тухай бүр | Цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хяналт шалгалтын дүнг нийтэд мэдээлэх | |
| **Төсөв, санхүүгийн болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр** | | | | |
| 17 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаар/<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>➢ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;<br>➢ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4; | Сар, улирал, хагас, бүтэн жилээр | Байгууллагын 2025 оны төсөв, гүйцэтгэлийг Шилэн дансны системд хуулийн хугацаанд, бүрэн байршуулсан байх | Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга, нягтлан хариуцсан ахлах мэргэжилтэн, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн |
| 18 | | Сар бүр, тухай бүр | Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллийг Шилэн дансны системд хуулийн хугацаанд байршуулсан байх | |
| 19 | | | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, бусад хяналт шалгалтын тайланг Шилэн дансны системд хуулийн хугацаанд, бүрэн байршуулсан байх | |
| **Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл, тайлбарыг хүлээн авах, мэдээллийн санд бүртгэх чиглэлээр** | | | | |
| 20 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах<br>Эрх бүхий үндэслэл:<br>➢ Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; | Жилдээ | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, хадгалах, зөвлөгөө өгөх | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан |
| 21 | | Тухай бүр | Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл, тайлбарыг хүлээн авах, цахим системд бүртгэх | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 22 | ➢ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2, 23.8; | | Нийтийн албанд томилогдох албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, ХАСУМ-ыг хянасан тухай мэдээллийг цахим санд оруулах | |
| **Албан хаагчдад авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, соён гэгээрүүлэх чиглэлээр** | | | | |
| 23 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Жилд 2-оос доошгүй удаа | Нийт албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргахад анхаарах асуудлын талаарх зөвлөмж чиглэл хүргүүлэх, АТГ-ын соён гэгээрүүлэх чиглэлийн мэдээ, мэдээлэл сурталчилгааг цахим хуудастай холбох | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан |
| 24 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.4; | Жилдээ | Төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулах | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо |
| 25 | | | Төрийн жинхэнэ албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах | Захиргаа, удирдлагын газрын сургалт хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн |
| 26 | | | Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, шуудангаар болон цахим шуудангаар хүлээн авах, биечлэн, санал хүсэлтийн хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх | Захиргаа, удирдлагын газрын дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан |
| 27 | | Тухай бүр | Ашиг сонирхлын зөрчил үүссэн буюу үүсэж болзошгүй тухай мэдэгдэл, тайлбар удирдах албан тушаалтанд гаргах, зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх | Байгууллагын дарга, Мэдүүлэг гаргагч нар |
| 28 | Давхар ажил эрхлэлтийн талаар албан тушаалтнуудад мэдээлэл өгөх, холбогдох хууль тогтоомжийн талаар танилцуулах<br>Эрх зүйн үндэслэл:<br>➢ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 17, 19 дүгээр зүйл; | 1 дүгээр сард | Хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын талаар албан хаагчдад мэдээлэх | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан<br>Хилийн боомт, орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтэн, салбар эрх бүхий албан тушаалтан |
| 29 | | Тухай бүр | Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх | |
| **Бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэх тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээний хүрээнд** | | | | |
| 30 | Эрх зүйн үндэслэл: | Тухай бүр | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 31 | ➢ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2;<br>➢ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2; | | Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | ахлах мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан |
| **Авлигатай тэмцэх газрын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | |
| 32 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | Тухай бүр | Шинээр болон шинэчлэн байгуулах бүх төрлийн гэрээнд авлигаас ангид байх, авлигыг мэдээлэх үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлүүлэх агуулгатай заалтыг тусгах | Захиргаа, удирдлагын газрын хуулийн мэргэжилтэн |
| 33 | | Жилдээ | Хууль тогтоомжийн хүрээнд өргөдөл гомдлын мөрөөр, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Захиргаа, удирдлагын газрын дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн |
| 34 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | Жилдээ | Эрсдэлд суурилсан авлигын эсрэг төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх | Захиргаа, удирдлагын газрын дарга, байгууллагын ЭБАТ |
| 35 | | 2, 3 дугаар улиралд | Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий постер 2-оос доошгүй төрөл, мөн зурагт хуудас, гарын авлага, брошюр хийж, нийтэд хүргэх | Хилийн боомт, орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтэн, салбар эрх бүхий албан тушаалтан |
| 36 | | Хагас, бүтэн жилд | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, дүнг албан хаагчдад танилцуулах | Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, хилийн боомт, орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтэн |

---oOo---